

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	В. Гэрэлцогт	Дугаар	L156
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Заг
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Ловон лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Өртөөний хурал болон Тэргүүний хурал	Сүм хийдийн дугаар	БХЗГ 087
Одоогийн сүм хийд	Балданлхам	Сүм хийдийн дугаар	БХЗГ 020
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 5	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Заг сумын Өртөөний хурал болон Тэргүүний хурлын
Асуулт:-Тус сумын төвд байрлах Балданлхам хийдийн ловон лам Ванчинсүрэн овогтой Гэрэлцогт гуайгаас тус сумын нутагт байсан Өртөөний хурал болон Тэргүүний хурлын тухай ярилцлага авч байна.

Хариулт:-Загийн Биндэрьяа хөх нуураас зүүн дор **Уулангийн** булан гэдэг газар том жижиг дуган байсан. Одоо хүмүүс Дуганы хонхор гэж нэрлэдэг болоод байна. **Эрдэнэжамъян** вангийн хошууны Тэргүүн богд багийн гол хурлын газар байсан. Гол шүтээн нь 10 догшин **Хангалын** нэг Балган **шалси** байсан. Халхын хошуу ноёны **түүхэнд** Биндэрьяа хөх нуурын чуулга уулзалтыг энэхүү тэргүүн багийн хурлын газар түшиглэн явуулдаг байсан ба чуулга уулзалтын үеэр ном хурах, цамын тоглолт зэрэг үйлүүдийг үйлддэг байсан байна. Энэ орчимд цамын дугуй, цамын дөрөлж гэж нэрлэдэг түүхэн газар, ус олон бий. Бага насаа нуур гаталж өнгөрүүлсэн, одоо 80

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гаруй настай цоохор хэмээх Дашээвэг гуай хуучлахдаа манай Тэргүүний хийд нь Мандаа агсны ойролцоо одоогийн **Дуганын** хонхорт байсан юм. Баруун, зүүн голын гэсэн 3 дуган байсан. Голын дуганаас хойш гарч нэг гэрт орно. Тэнд их шүтээн байсан. Тэргүүн хийдийн ойролцоо тойруулаад манай багийн гайгүй хөрөнгөтэй улсууд том жижиг мод чулуун байшингууд, 10 гаруй байсан юм. Хамгийн баянд тооцогддог байсан Дамба гуай буяных нь аятайхан барьсан чулуун байшинтай, одоогоор бол амбаар л юм даа. Түүний хажууд манай жижиг модон байшин байх. Манай аав **Чидинтоон** гэгч хүн байсан. Тэр байшингуудыг гол төлөв эд зүйлсээ хадгалдаг зориулалттай байсан.

1932 оны хавар манайх Заяын хүрээнд Хүрэн чулуунд байсан. Угаасаа Заг сум гэж байсан. Тэгэхэд би 10-аад настай байсан. Нуурын дуганыг буудаж, шатааж сүйтгэж байх үед манайхан ууланд дүрвэж гарч, хоол унд байхгүй, хойлог шувууны баастай цас идэж хэд хоносон. Тэргүүн багийн хурлын дуган гэдгээр их нэртэй газар байсан. Язгууртнуудаас Очир тэргүүний хүү Дамдин тэргүүн гэгч байсан. Тэргүүний хийдэд зод тавин, **чойжин** сахиус буулган гаднаас нь олон улс ирж хурал номонд оролцож байсан гэж хуучцуул ярьдаг байсан.

Пүрэвгүн жонон бэйсийн хошууны ч олон лам нар ирж хурал хурдаг байсан байна. Түүгээр ч барахгүй чуулгад ирсэн нэгэн ван хэргэмтэн дагалдаж явсан бараа бологчдынхоо хамт олон хоног ном хуруулж, суутал гэнэт цас ороод осгосон гэсэн нутаг буцах явдал нь хүндрэхэд манай хошуу ноёноос уг **вантанг** тав алдагдуулахгүйгээр өвөлжүүлэх зарлиг буулгаж тусдаа өвөлжөө гаргаж **засч** өгсөн. Хожмоо вангийн өвөлжөө хэмээн нэрлэгдэж, одоо ч тэр нэрээрээ байсаар байна.

Асуулт:-Тэргүүний хурлын лам нар ямар уул овоогоо хангайгаа тахидаг байсан бэ?

Хариулт:-Хүрэн бэлчир их Чандмань овоог, Золоо овоо, Цагаан овоо, Лүнгийн овоо энэ мэт овоонуудыг тахидаг байсан. Мөн Тахилгат хайрхан, Хөх хайрхан, **Ямбат** хайрхан, Цагаан хайрхан зэргийг тахидаг байсан.

Асуулт:-Тус сумын нутагт байсан Өртөөний хурлын талаар ярьж өгнө үү.

Хариулт:-Заг сумын төвийн ойролцоо Загийн өртөөний хурал гэж байсан. Одоогийн сумын төвийн дээхнэ, хүүхдийн овооны дэргэд шахуу байсан тухай тус сумын харьяат эдүгээ Улаанбаатар хотноо сууж буй үе залгамжилсан гэвш лам Пүрэвдаваа гуай хүүрнэж байсан. Ганц дугантай, гол шүтээн нь **Балданлхам**, Лхам бурхан, дагалдах шүтээн нь Улаан **сахиус**, Жамсран бурхан байжээ. Дуганы суурь буурь нарийн ажиглавал одоо ч мэдэгдэнэ. Асар том овоо байсан. Дээр үеийн 1945-1950 оны Заг сумын дэлгүүр, сургууль, холбооны чулуун барилгуудыг барихад овооны чулууг үхэр тэргээр зөөж бараг дуусгасан байна. 1921 онд Хатанбаатар Магсаржав **Улиастайд очиж** Ардын хувьсгалын үйл хэргийг эрчимжүүлэх шийдвэрийг авч цөөн цэрэгтэй баруун зүг рүү аялах замдаа цэрэг элсүүлэн явсаар энэ хүүхдийн овооны дэргэд буудаллан тахилга үйлдэж, өнжин хонон явсан тухай Заг сумын ууган дарга нарын нэг Хандын Ядамсүрэн гуайн **дурсамжинд** тэмдэглэгджээ. Тус хошуу сумын олон арван шашны зүтгэлтнүүд зөвхөн Байдрагийн хүрээ болон хошууны бусад багийн хурлуудад суудаг байсан. Тухайлбал, халх даяар алдартай Чин сүжигт Номун хааны хийдэд шавилан сууж байсан олон хүн байдаг. Тэдгээрийн заримаас дурьдвал цагаан гээг Гомбосүрэн гавж, түүний хүү Пүрэвдаваа, Монхор цагаан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гавж, Нохой цагаан, Хөх өвгөний Дорж, Лувсан, цээж хэмээх Барамсай гуай нарын номч мэргэдүүдийг нэрлэж болно.

Цагаан гэзэг гавж гэч хүний хүүхнээс нь гарсан хүүхэд нь би Гэрэлцогт лам гэдэг байгаа юм. Би 1995 -1996 онд лам болж 1997 онд Баянхонгор аймгийн Ламын гэгээний хийдэд шавилан сууж байгаад 1999 онд тус сумандаа эргэж ирсэн. Тэгээд энэ тус сумын хийдэд үйл ажиллагаа явуулж байна.

Асуулт:-Тус сумын төвд байгаа шинээр байгуулагдсан **Ванданлхам** хийдийн тухай ярьж өгнө үү.

Хариулт:-Тус хийд нь 2002 оны 8 сарын 23-нд анх байгуулагдсан юм. Энэ нь болохоор Нацагдоржийн Ганболд гэдэг ламыг хотоос авчирч, тэргүүн ламаар сонгож бид бүгд үйл ажиллагаа эхэлсэн. Тэр үед Содовжамц гэж лам байлаа. Одоо бурхан болчихсон. Оюунболд гэж **гэсгүй** байлаа. Содовжамц гэдэг нь бичээч лам хийж байсан юм, тэр үед нь. Наана нь 4, 5 хүүхдүүд. 10-аад хүний бүрэлдэхүүнтэй хурал эхэлсэн.

Асуулт:-Хийдийн барилга байгууламжийг барихад гол хөрөнгө оруулсан ч гэдэг юмуу, гол хувь нэмэр оруулсан ямар хүмүүс байгаа вэ?

Хариулт:-Энэ бол төсвийн байгууллагаар баригдсан гэж ярьдаг юм билээ, яг тэр хувь нэмэр оруулсан гэдэг нь улсуудын **мөнгө төгрөг** өгсөн юуг сайн мэдэхгүй.

Асуулт:-Энэ хийдийн маань гол шүтээн сахиус бурхан нь юу байгаа вэ?

Хариулт:-Энэ хийдийн гол шүтээн сахиус нь **Балданлхам** сахиустай юм байгаа юм. Дагалдах шүтээн нь Жамсран юм.

Асуулт:-Ямар уншлага, өдөртөө болоод сарын, жилийн ямар уншлага ном хурдаг вэ?

Хариулт:-Бид нар Цогчэн хурал хурдаг, наагуур нь заслын ном Сандуй, **Жадамба** гэхчлэн ойр зуурын **номнууд** хурдаг.

Асуулт:-Ойр орчмын ямар уул овоог тахиж шүтдэг үү?

Хариулт:-Хүрэн бэлчир, **Ямбат** хайрхан, Тахилга хайрхан, хоёр цагаан овоо, Лүнгийн овоо, Хүүхдийн овоо, Хөх нуурын овоо энэ бүгдийг тахидаг.

Асуулт:-Хэдэн сарын үед ямархуу ёс дэг жаягаар, шүүсээр ч гэдэг юмуу, яаж тахидаг вэ?

Хариулт:-Голцуухан цагаан идээгээр тахидаг юм даа. Зуны эхэн сарын шинийн 8, 15 гээд тахидаг юм.

Асуулт:-Хийдийн одоогийн байдал ямархуу хэдэн ламтайгаар үйл ажиллагаа явагдаж байна.

Хариулт:-Одоогийн байдлаар хүүхэд шүүд нийлсэн 7, 8 хүн байна.

Асуулт:-Гол томоохон лам нараас нь нэрлэвэл?

Хариулт:-Гол том лам гээд байх нэг их хүн байхгүй. Содовжамцын Батцолмон гэдэг лам бид хоёр л байна.

Тэгээд наад **бусад** нь дандаа сургуулийн хүүхдүүд байгаа.

Асуулт:-Одоо хийдийн өмнө тулгамдаж байгаа ямар асуудал бэрхшээл юу байна? Ямархуу санал хүсэлтэй явдаг вэ?

Хариулт:-Хөрөнгө мөнгөний байдал их хэцүү байх юм даа. Санхүү, эдийн засаг дээр их бэрхшээлтэй байх юм.

Тэрнээс ард түмэн маань хүрээлээд хурал номоо хуруулах гэсэн улсууд их байдаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Танай хийдийн байгуулагдсанаас хойш гол томоохон үйл явдлууд гэвэл юуг нэрлэж болох вэ?

Жишээлбэл, томоохон лам, хутагт **хувилгаадүүд** ирсэн, эсвэл гадагшаагаа сургууль соёлд лам нараа суралцуулсан ч гэдэг юмуу, гол үйл явдал гэвэл юуг хэлж болох вэ?

Хариулт:-Үйл явдал гэвэл хотоос манай тэргүүн хамба Чойжамц гуай морилж ирж байсан.

Асуулт:-Хэдэн оны үед?

Хариулт:-2007 оны 8 сарын үед нэг ирсэн. Тэрнээс өмнө гэвэл Өвөрхангай, Хархорин, Эрдэнэзуу хийдэд байсан Гомбосүрэнгийн Пүрэвдаваа гэдэг хүн 2003, 2005 оны үеэр хоёр дахин морилон ирж саатаж хурал ном хурж байсан.